



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 22 өдөр

Дугаар A/294

Сүхбаатар сум

### “Сэлэнгэ 2020 өртөөт марафон” уралдааныг зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.“а”, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жил, Монгол улсад орчин цагийн биеийн тамир, спортын хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан олон нийтэд биеийн тамирын үйл ажиллагаа, дасгал хөдөлгөөнийг сурталчлах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион байгуулах “Сэлэнгэ 2020 өртөөт марафон” уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.“Сэлэнгэ 2020 өртөөт марафон” уралдааныг “Ковид-19” цар тахлын цаг үеийн байдалтай холбоотойгоор өндөр зохион байгуулалтайгаар, урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг нарийн баримтлан 2020 оны 10 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3.“Сэлэнгэ 2020 өртөөт марафон” уралдааны ажлын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт 2020 оны 11 дүгээр сарын 02-ны дотср ирүүлэхийг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 10-р сарын 22 -ны өдрийн  
А/294 тоот захирамжийн хавсралт

## “СЭЛЭНГЭ 2020 ӨРТӨӨТ МАРАФОН” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жил, Монгол улсад орчин үеийн биеийн тамир спортын хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамирын үйл ажиллагаа, дасгал хөдөлгөөнийг сурталчлах, аж ахуйн нэгж байгууллага, салбарын ажилтнуудын хамтын ажиллагаа, ажлын туршлага солилцоход оршино.

### Хоёр. Зохион байгуулагч байгууллага, шүүгч, оролцогчдын бүрэлдэхүүн

#### 2.1. Зохион байгуулагчид:

- ✓ Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороо
- ✓ Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар;
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб,
- ✓ Боловсрол, соёл урлагийн газар;
- ✓ Биеийн тамир, спортын газар;
- ✓ Эрүүл мэндийн газар;
- ✓ Онцгой байдлын газар;
- ✓ Цагдаагийн газар;
- ✓ Хилийн цэргийн 0243-р анги
- ✓ Хилийн цэргийн 0101-р анги
- ✓ Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга;
- ✓ Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар
- ✓ Сэлэнгэ аймгийн Сурын холбоо
- ✓ Сэлэнгэ аймгийн “Мөнгөн хэгээс” дугуйн холбоо
- ✓ Сүхбаатар сумын “Зэлтэрийн зам” ХХК

#### 2.2. Шүүгчдийн бүрэлдэхүүн:

Өртөөт марафоныг хамтран зохион байгуулах Сэлэнгэ аймаг дахь хэлтэс, агентлагуудын салбар тус бүрийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл болон багш, дасгалжуулагчид, холбоодын оролцоотой цүүн явуулна.

#### 2.3. Оролцогчдын бүрэлдэхүүн:

Аймаг орон нутгийн 17 сум, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дунд зохион байгуулна.

Нэг баг 4 хүнээс бүрдэх бөгөөд нийт 17 сум, 31 байгууллагын 168 хүн оролцоно.  
Үүнд:

1. 17 сумын 6 тосгон тус бүрээс насанд хүрэгч болон ахмад насны ангилалд оролцох 1 баг буюу нийт 72 хүн;

3. Сүхбаатар сумын 8 багаас 2 насны ангилалд нийт 32 хүн;

4. Хэлтэс, агентлагуудаас 22 багийн 88 хүн

5. Хувийн хэвшлийн байгууллага, спортын цогцолбор, холбоонуудаас 5 багийн 20 хүн

### **Гурав. Бүртгэл, хугацаа, зохион байгуулалт**

3.1. Аймгийн Биеийн тамир спортын газраас өртөөт марафоны ангилал тус бүрд оролдох багуудыг "Спортын ордон" 303 номерийн өрөөнд /арга зүйч Л.Азжая /[selengesport@gmail.com](mailto:selengesport@gmail.com)/ цахим хаягаар бүртгэнэ .

3.2. "Сэлэнгэ 2020" өртөөт марафонд оролцох нийт тамирчид 2020 оны 10 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт Партизаны талбайгаас том оврын 2 автобусанд сууж, тэмцээн болох газарт хүргэж буцааж авчирна.

3.3. "Сэлэнгэ 2020" өртөөт марафоны нээлтийн ажиллагааг 2020 оны 10 дүгээр сарын 24-ний өдрийн 10:30 цагт Сайханы хөтлийн талбайд хийнэ.

Нээлтийн ажиллагааны дараа оролцогч багуудад мандат олгон сугалаа хийж, өртөөний зураглал /маршрут/-ыг танилцуулан өртөө тус бүрийг хариуцуулсан байгууллага, өртөөний даалгаврыг танилцуулан үйл ажиллагааг эхлүүлнэ.

Оролцогч багуудад зохион байгуулах газраас энгэрийн номер олгонс

Өртөөт марафоны хаалтын ажиллагааг 17:00-18:00 цагийн хооронд хийж, шагналт байр эзэлсэн оролцогчдод урамшууллыг гардуулснаар үйл ажиллагааг дуусгавар болгоно.

Өртөөт марафоны тэмцээнд оролцох багууд хувцсаа жигдэлсэн, байгууллагын туг, хаягтай байна.

### **Дөрөв. Багийн бүрэлдэхүүн**

4.1. Бүх оролцогчид заавал **иргэний үнэмлэхтэй** үйл ажиллагаанд оролцоно.

4.2. Бичиг баримтын зөрчил гаргасан багийг үйл ажиллагаанаас **багаар нь** хасна.

4.3. "Сэлэнгэ 2020" өртөөт марафоныг дараах 2-н насны ангиллаар явуулна.

**АХМАДЫН АНГИЛАЛ: Нэг баг 4 хүнтэй.**

50 наснаас дээш эрэгтэй 2 хүн  
45-аас дээш насны эмэгтэй 2 хүн.

**ЗАЛУУЧУУДЫН АНГИЛАЛ: Нэг баг 4 хүнтэй.**

25-40 насны эрэгтэй 2 хүн

25-40 насны эмэгтэй 2 хүн.

**Тав. Өртөөний даалгавар, дүн гаргах, урамшуулал**

- 5.1. "Сэлэнгэ 2020" өртөөт марафоны даалгаврыг нээлтийн ажиллагааны дараа танилцуулна.
- 5.2. Багууд ангилал тус бүрт 6 өртөө буюу 2-2,5 км замыг туулах бөгөөд гараанаас гарахад цагийг эхлүүлж, багийн хамгийн сүүлчийн гишүүн барианд орсноор цагийг дуусгавар болгоно
- 5.3. Багууд өртөө тус бүрд гүйцэтгэх даалгаврын тайлбар хуудсыг тухайн өртөөн дээр очсоны дараа шүүгчээс авч, нарийвчлан танилцаж, даалгаврыг чанартай биелүүлнэ.
- 5.4. Багуудын өртөө тус бүрийн даалгаврыг гүйцэтгэсэн хугацааны цагийн нийлбэр үзүүлэлтэд торгуулийн цагийг нэмж, шагналын цагийг хасаж тооцон дүнг гаргаж, цагийн нийлбэр үзүүлэлтийг үндэслэн 2 ангилал тус бүрд эхний 3 баг буюу нийт 6 багийг шалгаруулна.
- 5.5. Шалгарсан 6 баг тус бүрд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хорооны Өргөмжлөл, багийн гишүүдийг спортын хэрэглэлээр урамшуулна.
- 5.6. "Сэлэнгэ 2020" өртөөт марафонд аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүний идэвх зүтгэлийг үнэлэн тусгай шагналаар дэмжиж урамшуулна.

**Өртөө тус бүр гүйцэтгэх дасгалууд:**

"Сэлэнгэ 2020" өртөөт марафоны өртөө тус бүр дээр очиход хариуцсан тухайн байгууллагын онцлог болон үйл ажиллагаатай холбоотой тоглоом, наадгай, сонирхолтой спортын төрлийг сонгон авхаалж, самбаа, хурд, хүч, уян хатан, эр зоригийг хариулсан дөхүүлэх дасгалуудаар биет үйл ажиллагааг сонгон хийж болно.

***" ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТ " /ОБГазар /***

Хэрэглэгдэх зүйлс: Секундомер, Хорт утааны баг /банктай хоолой / 8 (дутагдахгүйгээр). 4 ширээ

Дасгалын тайлбар. Багийн бүх гишүүд ирсний дараа нэгэн зэрэг гази командаар багийг өмсөж банктой хоолойг холбож дуусга командаар даалгавар биелэгдэнэ. Буруу өмсөх, буруу холбох илүү үйлдэл хийх зэрэгт алдааны оноо нэмэгдэнэ.

## **“МОНГОЛ БИЧГЭЭР БИЧЬЕ” / Боловсрол, соёл урлагийн газар/**

Хэрэглэгдэх зүйлс: Секундомер, цагаан самбар 4 ширхэг, самбарын үзэг 10 ширхэг (дутагдахгүйгээр) 2 ширээ

Дасгалын тайлбар: Багаас томилогдсон 1 гишүүн тусгайлан бэлтгэсэн самбарт “спорт” гэсэн үгийг монгол бичгээр бичнэ. Үгийг зөв бичсэний дараа дараагийн өртөө рүү багийн бүх гишүүд гүйнэ.

## **“ДУГУЙ УНАХ” /Аймгийн “Мөнгөн хэгээс” дугуйн холбоо /**

Хэрэглэгдэх зүйлс: Секундомер, унадаг дугуй 8 ширхэг, туулах замыг хэмжиж тэмдэглэсэн байх, 1 ширээ

Дасгалын тайлбар: Багийн бүх гишүүд дугуй унан 100м замыг туулснаар дараагийн өртөө рүү шилжинэ.

## **“БАЙ ОНОХ” /Аймгийн Сурын холбоо/**

Хэрэглэгдэх зүйлс: Нум сум 4, 2 ширхэг бай буюу өрөг хасаа. 2 ширхэг жижиг туг, 2 ширээ

Дасгалын тайлбар: Багийн гишүүд тус бүр тодорхой өгөгдсөн зайд байрлуулсан өрөг зурхайд нэг хүн 2 сум тавьж, 8 хүний оносон дээд амжилтаар дүгнэнэ Багийн гишүүд тус бүр дасгалыг гүйцэтгэж дараагийн өртөө рүү шилжинэ.

## **“ҮЛЭЭЛТ” /Сүхбаатар сумын ЗДТГазар /**

Хэрэглэгдэх зүйлс: Секундомер, нэг удаагийн аяга 50 ширхэг, цэвэр ус 50 ширхэг, ширээний теннисний бөмбөг 50 ширхэг, 2 ширээ

Дасгалын тайлбар: Эгнүүлэн тавьсан 4-н ширхэг нэг удаагийн хуванцар аяганы дундаас дээгүүр хэмжээнд ус хийнэ. Багийн гишүүн тус бүрд 1,1 ширхэг ширээний теннисний бөмбөг өгнө. Багийн гишүүд шүүгчийн дохиогоор ширээний теннисний бөмбөгөө эхний аяганд хийн үлээж, дараагийн аяга руу оруулна. Энэ маягаар бүх гишүүд тус бүр тус тусын аяганд ширээний теннисний сүүлчийн бөмбөгөө үлээн оруулснаар дараагийн өртөө рүү шилжинэ.

Анхааруулга: Заавал тухайн багийн сүүлчийн гишүүн ширээний теннисний бөмбөгийг сүүлчийн аягандаа үлээн оруулсны дараа багаараа дараагийн өртөө рүү шилжинэ.

### **“ГАЛТ ТЭРЭГ”/Хилийн цэргийн 0101-р анги/**

Хэрэглэгдэх зүйлс: Секундомер, бөмбөлөг 50 ширхэг (агаарын шаар), туулах замыг тэмдэглэх шохой. конус 20ш

Дасгалын тайлбар: Багийн гишүүд ар, араасаа цуваа болон зогсохдоо хүн тус бүрийн хооронд /дундаа/ 1 ширхэг бөмбөлгийг хавчуулан байршуулна. Гишүүд дундаа хавчуулсан бөмбөлгийг гар оролцуулахгүйгээр зөвхөн биеэрээ тулж тогтоон цуваагаар тэмдэглэсэн замыг туулснаар дараагийн өртөө рүү шилжинэ.

Тэмдэглэсэн зайдсаар байрлуулж болно. Багийн гишүүд бөмбөлгийг тэмдэглэсэн замыг туулахдаа унагаавал, унагасан газраас бөмбөлгийг дахин хавчуулан тогтоож дасгалыг эхэлж, үргэлжлүүлэн гүйцэтгэснээр дараагийн өртөө рүү шилжинэ.

### **“ГРАНАТ ШИДЭХ” / ОБГ /**

Хэрэглэгдэх зүйлс: Ф-1 гранат 8 ш, жижиг дарцаг 5 ширхэг, 2м радиустай тойрог 2-ыг, ширээ бэлтгэх

Дасгалын тайлбар. Багийн бүх гишүүд ирсний дараа эрэгтэй тамирчид 25 м зайд байгаа байнд, эмэгтэй тамирчид 15м зайд байгаа байнд гранатыг гишүүн бүр 1 шидэж оруулна. Буруу шидэх, байнд тусаагүй үйлдэл бүрд алдааны оноо нэмэгдэнэ.

### **“ХААЛГАНД БӨМБӨГ ОРУУЛАХ”/ Хилийн цэргийн 0243-р анги/**

Хэрэглэгдэх зүйлс: Мини хөл бөмбөгийн хаалга 2 ш, тор, хөл бөмбөгийн бөмбөг 4 ш, конус 15 ширхэг бэлтгэх

Дасгалын тайлбар. Багийн бүх гишүүд ирсний дараа ээлжлэн эрэгтэй эмэгтэй тамирчид мини хөл бөмбөгийн хаалганд эрэгтэй 15 м зайнаас, эмэгтэй 10 м зайнаас бөмбөгийг хаалганд өшиглөж оруулна. Хаалганд оруулаагүй үйлдэл бүрд алдааны оноо нэмэгдүүлнэ.

### **Зургаа. Багийн амжилтыг хүчингүй болгох нөхцөлүүд**

- 6.1. Оролцогч багууд өртөө алгассан тохиолдолд;
- 6.2. Өртөөний дундуур багийн гишүүд солигдсон тохиолдолд;
- 6.3. Өртөөт марафоны талбайд зөвшөөрөлгүй орж, шүүгч бусад багийг даалгаарын дасгалаа биелүүлэхэд саад учруулсан тохиолдолд;
- 6.4. Зөвшөөрөгдөөгүй тоног төхөөрөмж, спортын хэрэглэл, хэрэгсэл ашигласан тохиолдолд;
- 6.5. Бусдаас мэдээлэл авах буюу бусдад мэдээлэл өгөх зорилгоор дохионы хэл болон биеийн хөдөлгөөн, дохио, зангаа, аливаа үйлдэл үзүүлсэн тохиолдолд;
- 6.6. Өртөөт марафоны явцад бусад багийн оролцогчдод зам маршрутыг буруу зааж өгөх, даалгаварын дасгал биелүүлэхэд нь саад учруулсан нь илэрсэн тохиолдолд;

- 6.7. Шүүгч болон бусад багийн гишүүдтэй ёс бус үг хэллэг хэрэглэн харьцах, хэрдгий зан авир гаргасан нь тогтоогдсон тохиолдолд;
- 6.8. Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үед.

### **Долоо. Сурталчилгаа**

“Сэлэнгэ 2020” өртөөт марафон явагдах газрын байршил зураглал гаргаж Биеийн тамир спортын газрын вэб сайтад байршуулна.

“Сэлэнгэ 2020” өртөөт марафоны талаарх фото зураг, дүрсжүүлсэн бичлэгийг телевизээр, холбогдох мэдээллийг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хорооны вэб сайтад байршуулан нийтэд сурталчилна.

---oOo---